



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар A/315

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Содон номин констракшн ХХК", "Айникс-Инженеринг ХХК" нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийг Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч /Ө.Оюунсууд/-ийг аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр /хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар/ томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэнг түр орлон гүйцэтгэгч /Ө.Оюунсууд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

